



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 1156

Чойр


Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.13, Согтууруулах ундааны эрэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15<sup>1</sup> дүгээр зүйлийн 15<sup>1</sup>.4, 40 дүгээр зүйлийн 40.9, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянтал сумын Лүн багт байрлах "Оюут боржигин" ХХК-ийн хүнсний дэлгүүрт сул болон өндөр агууламжтай согтууруулах ундаагаар худалдах тусгай зөвшөөрлийг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 2029 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай.

2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгүүдэд тавигдах нөхцөл шаардлагыг бүрэн хангаж ажиллахыг "Оюут боржигин" ХХК-ийн захирал С.Оюунчимэгт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Нэргүйцэцэг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Хонгор), Цагдаагийн хэлтсийн дарга (хурандаа Ц.Баярхүү), Эрүүл мэндийн газрын дарга (Ц.Мөнх-Од), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Э.Түвшинзаяа), Татварын хэлтсийн дарга (П.Энх-Оюун), Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (О.Байгальсайхан), Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Жамбаасүрэн) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Г.БАТСУУРЬ

